

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/157/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17_Тос95917377
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/157-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ
СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.БҮРЭНЦОГТ
ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,000,607.62	29,653,381.54
33	АВЛАГА	1,763,241.56	1,864,392.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	135,549.55	50,000.00
33500	Бусад авлага	1,627,692.01	1,814,392.01
33510	Байгууллагаас авах авлага	1,161,300.01	1,348,000.01
33520	Хувь хүмүүсээс авах авлага	466,392.00	466,392.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,237,366.06	27,788,989.53
35400	Хангамжийн материал	9,237,366.06	27,788,989.53
35410	Бичиг хэргийн материал	222,600.00	1,938,323.47
35420	Аж ахуйн материал	9,014,766.06	23,571,066.06
35460	Хүнсний материал	-	2,279,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,012,058,875.96	970,918,652.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,012,058,875.96	970,918,652.76
39200	Биет хөрөнгө	948,836,475.96	907,696,252.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	884,329,874.00	884,329,874.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,648,968.13)	(86,474,326.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,085,775.80)	(10,685,775.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,322,577.70	108,622,577.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,008,983.08)	(63,542,307.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,473,129.10	74,873,129.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,073,336.20)	(31,673,676.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,506,217.64	10,506,217.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,600,000.00)	(2,900,000.00)
39217	Ном	7,621,740.73	8,640,540.73
39300	Биет бус хөрөнгө	63,222,400.00	63,222,400.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,972,400.00	61,972,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,023,059,483.58	1,000,572,034.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	429,013.57
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	429,013.57
41300	Өглөг	-	429,013.57
41360	Бусад өглөг	-	429,013.57
41361	Байгууллагад төлөх өглөг	-	429,013.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,023,059,483.58	1,000,143,020.73
51	Засгийн газрын хувь оролцоо	1,023,059,483.58	1,000,143,020.73
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,443,955.60	275,443,955.60
51200	Хуримтлагдсан үр дүн	(25,912,676.63)	(48,829,139.48)
51210	Өмнөх үеийн үр дүн	16,036,129.06	(25,912,676.63)
51220	Тайлант үеийн үр дүн	(41,948,805.69)	(22,916,462.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	773,528,204.61	773,528,204.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,023,059,483.58	1,000,572,034.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	653,849,606.18	672,109,171.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,210,386.18	16,414,371.47
120	Нийтлэг татварын бус орлого	7,210,386.18	16,414,371.47
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,467,192.73	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,743,193.45	16,414,371.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	646,639,220.00	655,694,800.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515,503,900.00	522,144,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	515,503,900.00	522,144,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,776,200.00	6,362,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,597,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,776,200.00	1,765,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	117,359,120.00	127,187,800.11
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	117,359,120.00	127,187,800.11
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	695,798,411.87	695,025,634.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,798,411.87	695,025,634.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	663,258,362.11	667,210,111.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,464,387.00	419,394,654.00
210101	Үндсэн цалин	287,176,524.00	299,183,494.00
210102	Нэмэгдэл	88,122,369.00	96,332,192.00
210104	Урамшуулал	35,165,494.00	23,878,968.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,895,216.74	56,161,286.12
210201	Тэтгэврийн даатгал	35,379,338.01	39,347,729.64
210202	Тэтгэмжийн даатгал	4,049,943.70	4,203,389.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,496,316.95	3,362,712.42
210204	Ажилгүйдлийн даатгал	815,418.77	840,677.58
210205	Эрүүл мэндийн даатгал	8,154,199.31	8,406,777.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,359,120.00	126,742,200.11
210301	Гэрэл, цахилгаан	3,488,800.00	4,005,700.11
210302	Түлш, халаалт	106,082,976.00	114,319,520.00
210303	Цэвэр, бохир ус	7,787,344.00	8,416,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,902,200.00	5,925,448.00
210401	Бичиг хэрэг	1,157,200.00	421,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	218,100.00	354,000.00
210404	Ном, хэвлэл	1,769,900.00	1,626,148.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,815,500.00	434,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,741,500.00	1,289,200.00
2105	Нормативт зардал	518,900.00	300,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,800.00	207,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	415,100.00	93,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	797,200.00	1,273,100.00
210604	Урсгал засвар	797,200.00	1,273,100.00
2107	Томилолт, зочны зардал	67,100.00	162,900.00
210702	Дотоод албан томилолт	67,100.00	162,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,163,460.00	4,443,000.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	587,460.00	3,957,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,090,778.37	52,806,623.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,809,500.00	1,420,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,931,600.00	1,527,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,349,678.37	49,859,023.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,540,049.76	27,815,523.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,355,143.50	18,518,141.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,955,143.50	18,518,141.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,184,906.26	9,297,382.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,184,906.26	9,297,382.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(41,948,805.69)	(22,916,462.85)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(41,948,805.69)	(22,916,462.85)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	646,639,220.00	655,694,800.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	646,639,220.00	655,694,800.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515,503,900.00	522,144,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	515,503,900.00	522,144,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,776,200.00	6,362,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,597,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,776,200.00	1,765,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	117,359,120.00	127,187,800.11
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	117,359,120.00	127,187,800.11
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,674,420.00	646,976,000.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,674,420.00	646,976,000.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,521,283.74	616,694,177.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,466,387.00	419,394,654.00
210101	Үндсэн цалин	287,178,524.00	299,183,494.00
210102	Нэмэгдэл	88,122,369.00	96,332,192.00
210104	Урамшуулал	35,165,494.00	23,878,968.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,895,216.74	55,646,723.00
210201	Тэтгэврийн даатгал	35,379,338.01	38,833,166.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,049,943.70	4,203,389.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,496,316.95	3,362,711.54
210204	Ажилгүйдлийн даатгал	815,418.77	840,677.58
210205	Эрүүл мэндийн даатгал	8,154,199.31	8,406,778.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,359,120.00	126,742,200.11
210301	Гэрэл, цахилгаан	3,488,800.00	4,005,700.11
210302	Түлш, халаалт	106,082,976.00	114,319,520.00
210303	Цэвэр, бохир ус	7,787,344.00	8,416,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,902,200.00	5,783,100.00
210401	Бичиг хэрэг	1,157,200.00	421,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	1,800,000.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	218,100.00	354,000.00
210404	Ном, хэвлэл	1,769,900.00	1,579,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,974,100.00	434,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,582,900.00	1,193,800.00
2105	Нормативт зардал	518,900.00	300,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,800.00	207,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	415,100.00	93,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	797,200.00	1,273,100.00
210604	Урсгал засвар	797,200.00	1,273,100.00
2107	Томилолт, зочны зардал	67,100.00	162,900.00
210702	Дотоод албан томилолт	67,100.00	162,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,163,460.00	4,443,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	587,460.00	3,957,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,351,700.00	2,947,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,420,100.00	1,420,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,931,600.00	1,527,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,153,136.26	30,281,823.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,784,430.00	20,797,741.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,384,430.00	20,797,741.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	186,700.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	186,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	183,800.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	183,800.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,184,906.26	9,297,382.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,184,906.26	9,297,382.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,964,800.00	8,718,800.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,964,800.00	8,718,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,964,800.00	8,718,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,964,800.00	8,718,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,964,800.00	8,718,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,964,800.00)	(8,718,800.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	16,036,129.06	1,065,008,289.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	16,036,129.06	1,065,008,289.27
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(41,948,805.69)	(41,948,805.69)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(25,912,676.63)	1,023,059,483.58
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(25,912,676.63)	1,023,059,483.58
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(25,912,676.63)	1,023,059,483.58
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн олз,	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,916,462.85)	(22,916,462.85)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	275,443,955.60	773,528,204.61	(48,829,139.48)	1,000,143,020.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	664,880,700.00	640,034,518.11	24,846,181.89	96.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,880,700.00	640,034,518.11	24,846,181.89	96.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	643,582,900.00	619,236,777.11	24,346,122.89	96.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,875,800.00	419,394,654.00	4,481,146.00	98.94
210101	Үндсэн цалин	296,607,800.00	299,183,494.00	(2,575,694.00)	100.87
210102	Нэмэгдэл	103,385,700.00	96,332,192.00	7,053,508.00	93.18
210104	Урамшуулал	23,882,300.00	23,878,968.00	3,332.00	99.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,808,800.00	55,646,723.00	3,162,077.00	94.62
210201	Тэтгэврийн даатгал	41,881,700.00	38,833,166.52	3,048,533.48	92.72
210202	Тэтгэмжийн даатгал	4,231,800.00	4,203,389.12	28,410.88	99.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,385,400.00	3,362,711.54	22,688.46	99.33
210204	Ажилгүйдлийн даатгал	846,400.00	840,677.58	5,722.42	99.32
210205	Эрүүл мэндийн даатгал	8,463,500.00	8,406,778.24	56,721.76	99.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,291,000.00	126,742,200.11	15,548,799.89	89.07
210301	Гэрэл, цахилгаан	6,499,000.00	4,005,700.11	2,493,299.89	61.64
210302	Түлш, халаалт	130,086,400.00	114,319,520.00	15,766,880.00	87.88
210303	Цэвэр, бохир ус	5,705,600.00	8,416,980.00	(2,711,380.00)	147.52
2104	Хангамж, бараа материалын зардал	4,335,700.00	4,125,200.00	210,500.00	95.14
210401	Бичиг хэрэг	241,100.00	240,600.00	500.00	99.79
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	564,000.00	354,000.00	210,000.00	62.77
210404	Ном, хэвлэл	218,300.00	218,300.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	318,500.00	318,500.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,193,800.00	1,193,800.00	-	100.00
2105	Нормативт зардал	300,900.00	300,900.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,700.00	207,700.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	93,200.00	93,200.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,973,100.00	8,973,100.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,300,000.00	6,300,000.00	-	100.00
210602	Тавилга	1,400,000.00	1,400,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,273,100.00	1,273,100.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	162,900.00	162,900.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	162,900.00	162,900.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,887,100.00	943,500.00	943,600.00	50.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	825,100.00	457,500.00	367,600.00	55.45
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,062,000.00	486,000.00	576,000.00	45.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,947,600.00	2,947,600.00	-	100.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,420,100.00	1,420,100.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,527,500.00	1,527,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,297,800.00	20,797,741.00	500,059.00	97.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,297,800.00	20,797,741.00	500,059.00	97.65
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,297,800.00	20,797,741.00	500,059.00	97.65
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	664,880,700.00	640,034,518.11	24,846,181.89	96.26
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	522,144,100.00	512,846,718.00	9,297,382.00	98.22
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	522,144,100.00	512,846,718.00	9,297,382.00	98.22
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	142,736,600.00	127,187,800.11	15,548,799.89	89.11
320001	Орон нутгийн төсвөөс	142,736,600.00	127,187,800.11	15,548,799.89	89.11
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	9,395.00	71.00	9,324.00	0.76
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35.00	35.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	333.00	-	333.00	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	333.00	-	333.00	-
630001	Төрийн өмчит ЕБС	333.00	-	333.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	9,026.00	35.00	8,991.00	0.39
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	26.00	26.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9,000.00	9.00	8,991.00	0.10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,597,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,597,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,597,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,876,200.00
210401	Бичиг хэрэг	-	181,000.00
210404	Ном, хэвлэл	-	1,579,200.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210406	Хог хаягдал, хортон шавж	-	116,000.00
2105	Нормативт зардал	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,499,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	800,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	800,500.00
223001	Бусад хөрөнгө	-	800,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	800,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,179,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,179,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,597,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,582,100.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад, бүх талуудтай хамтран ажиллая” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголцотой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 695,798.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,957.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 4,870.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,487.4 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Ажилчидтай холбогдсон авлага	135.50	50.00	(85.50)
Хувь хүнээс авах авлага	466.40	466.40	0.00
Байгууллагаас авах авлага	1,161.30	1,348.00	186.70
Бараа материал	9,237.30	27,789.00	18,551.70
Үндсэн хөрөнгө	1,012,058.90	970,918.70	(41,140.20)
Нийт хөрөнгө	1,023,059.40	1,000,572.00	(22,487.40)
Өр төлбөр		429.00	429.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,023,059.40	1,000,143.00	(22,916.40)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,023,059.40	1,000,572.00	(22,487.40)

Тайлант онд дансны авлага 101.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой авлага 85.5 төгрөгөөр буурч, 186.7 мянган төгрөгийн түрээсийн номны төлбөр тооцоог буруу хийж, байгууллагаас авах авлагаар тусгаснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,551.7 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 14,556.3 мянган төгрөгийн лабораторийн сургалтын хэрэглэгдэхүүн, 1,762.7 мянган төгрөгийн ном сурах бичиг тараах материал үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,166,444.7 мянган төгрөг болж өмнөх оноос 8,718.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,300.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил 1,400.0 мянган төгрөгийн хувцасны шкаф, 1,018,8 мянган төгрөгийн номыг худалдан авсантай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөрийн данс 429.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллын алдаанаас үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,000,143.0 мянган төгрөг болж 22,916.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 672,109.2 мянган төгрөг болж өмнөх оноос 18,259.6 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Энэ нь тайлант хугацаанд 16,414.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 695,798.4 мянган төгрөг болж өмнөх оноос 772.8 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн нь байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхонтуул сумын Рашаант тосгоны сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 762,241.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 114,222.3 мянган төгрөгөөр бууруулж, 664,880.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **664,880.7** мянган төгрөгийн төсөв баталснаас 522,144.1 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 142,736.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 522,144.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 127,187.8 мянган төгрөг, нийт 649,331.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 640,034.5 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 9,297.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **640,034.5** мянган төгрөг буюу 96.3 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 4,481.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 3,162.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн орлого 181.0 мянган төгрөг, БСГ-аас 4,416.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал 116.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3,499.5 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 800.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 181.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Түрээсийн номын орлогоос 1,582.1 мянган төгрөг орж холбогдох дансаар дамжуулан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуульд 664,880.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 640,034.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 91,481.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 66,075.9 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,580.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 23,824.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Тайлант онд 16,269.3 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн оны батлагдсан төлөвлөгөөг 15,560.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 20,256.3 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.
- Нэмэлт санхүүжилтийн тайланд 183.8 мянган төгрөгийн зардлыг дутуу тайлагнасан.
- Бараа материалын дансны ангиллыг 95.4 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх үеийн үр дүн 13,710.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн байсныг залруулав.

4.2 Албан шаардлага

1. Захирал Н.Бүрэнцогтод сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/328 дугаар захирамжаар 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 4.6. “Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс түрээсийн номны 186.7 мянган төгрөгийн авлага, НДШ-ийн 429.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 23,824.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн

баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны сургууль	10	91,481.2	6	66,075.9			2	1,580.6	2	23,824.7